

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны . . . дугаар
сарын . . .ны/ий өдрийн дугаар
тогтоолын . . . дугаар хавсралт

**Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр,
тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт малыг отор, нүүдэл хийх, үзэсгэлэн худалдаанд оролцох, нийтийг хамарсан уралдаан, тэмцээнд оролцох болон мал, мах бэлгэлийн зориулалтаар засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжих, дамжин өнгөрөхөд энэхүү журмыг баримтална.

1.2. Энэхүү журмаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан малын шилжилт хөдөлгөөн хийхтэй холбогдон гарах харилцааг зохицуулна.

Хоёр. Малын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах

2.1. Мал, амьтны өвчинтэй тэмцэх арга хэмжээг батлаглагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн мал, амьтныг отор, нүүдэл хийх, үзэсгэлэн худалдаанд оролцох, нийтийг хамарсан уралдаан, тэмцээнд оролцох болон мал, мах бэлгэлийн зориулалтаар засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжих, дамжин өнгөрөхийг зөвшөөрнө.

2.2. Отор нүүдлийн зорилгоор олон тооны мал шилжүүлэгч аймаг, сум болон хүлээн авагч тал мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчаар ахлуулсан ажлын хэсэг томилон шилжилт хөдөлгөөнд бүрэн хяналт тавина.

2.3. Отор нүүдэл хийх зорилгоор олон тооны малыг нэг аймгийн харьяа нэг сумаас нөгөө суманд шилжихэд хүлээн авах сумын мал эмнэлгийн тасаг шилжүүлэгч сумын мал, амьтны халдварт болон шимэгчтэх өвчний тархвар зүйн судалгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг үндэслэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3 дахь хэсэгт зааснаар урьдчилан зөвшөөрөх бөгөөд Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.8, 52.9 дэх хэсгийг баримтлан Засаг дарга хүлээн авах эсэх хариу өгнө.

2.4. Хүлээн авагч сумын мал эмнэлгийн тасаг өөрийн нутаг дэвсгэрт отор, нүүдлийн зорилгоор нэвтрэхийг зөвшөөрсөн тохиолдолд шилжүүлэгч сумын мал эмнэлгийн тасаг халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж, гэрээт мал эмнэлгээс тодорхойлолт олгоно.

2.5. Нэг аймгийн нутаг дэвсгэрээс нөгөө аймгийн нутаг дэвсгэрт отор нүүдэл хийх зорилгоор олон тооны мал шилжилт хөдөлгөөн хийхэд хүлээн авач талын мал эмнэлгийн газрын санал дүгнэлтийг үндэслэн хүлээн авах, эсэх шийдвэрийг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.8, 52.9 дэх хэсгийг баримтлан Засаг дарга гаргана.

2.6. Хүлээн авагч аймгийн Засаг дарга отор нүүдлийн зориулалтаар олон тооны мал хүлээн авах хариу өгсөн тохиолдолд мал шилжилт хөдөлгөөн хийлгэх сумын мал эмнэлгийн тасаг халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж, гэрээт мал эмнэлгээс тодорхойлолт олгоно.

2.7. Отор нүүдлийн зорилгоор олон тооны мал шилжүүлсэн аймаг, сумын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих чиг үүрэгтэй томилогдсон ажлын хэсэгт хүлээн авагч талын нутаг дэвсгэрт Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3. дахь хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлнэ.

2.8. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн уулийн 7 дугаар зүйлийн 7.3.3. дахь хэсэгт заасн дагуу гамшигийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, хашаа хороог халдваргүйжүүлэх зардлыг мал оторлуулагч аймаг, сум хариуцна.

2.9. Үзэсгэлэн худалдаанд оролцох, нийтийг хамарсан уралдаан, тэмцээнд оролцох болон мал, мах бэлгэлийн зориулалтаар засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжилт хөдөлгөөн хийхэд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлыг хангана.

2.10. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас тогтоосон мах бэлтгэл, отор нүүдлийн зорилгоор аймаг дамжин мал туух тууврийн замын чиглэлийн дагуу шилжилт хөдөлгөөнийг хийнэ.

2.11. Тухайн сумын нутаг дэвсгэрээр хот хоорондын төв зам дамжин өнгөрдөг бол мал, амьтан тээвэрлэн дамжин өнгөрдөг тээврийн хэрэгсэл түр саатах, мал амьтыг түр амрааж болох цэгийг сумын мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн байцаагчийн дүгнэлт, санлыг үндэслэн тухайн сумын Засаг дарга тогтоож нийтэд мэдээлнэ.

2.12. Халдварт өвчингүй, тайван байдлыг тогтоосон аймаг, сум, эрчимжсэн аж ахуй болон халдварт өвчингүй тусгаарласан бүсээс мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийхэд халдварт өвчингүй тайван байдлыг баталгаажуулах стратеги, халдварт өвчнийг хяналтанд авах төлөвлөгөө, малын ерөнхий эмчийн баталсан зааврыг баримтална.

2.13. Байгалийн гамшигт үзэгдэл шуурганд уруудсан олон тооны малыг буцаан нутаг дэвсгэрт нь тээвэрлэж, тууварлаж ирүүлэхэд тухайн мал хүрсэн газрын гэрээт мал эмнэлэг эрүүл мэндийн үзлэг хийж халдварт өвчний голомт гараагүй нөхцөлд тодорхойлолт олгоно. Мал эмнэлгийн тасаг тухай малын гарал үүслийг тогтоож тодорхойлолтыг үндэслэн мал эмнэлгийн гэрчилгээ олгож тээвэрлэж, тууварлахыг зөвшөөрнө.

2.14. Байгалийн гамшигт үзэгдэл шуурганд уруудсан олон тооны малыг г мал эмнэлгийн гэрчилгээгүй буцаан нутаг дэвсгэрт нь тээвэрлэж, тууварлахыг хориглоно.

Гурав. Тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах

3.1. Мал, амьтан тээвэрлэж, тууварлах замд хяналтын цэгийн болон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6. дахь хэсэгт зааснаас гадна дараахь үндэслэлээр түр саатуулна.

3.1.1. Мал эмнэлгийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш хяналтын цэгт ирэх хугацаанд тухай мал, амьтны гарал үүсэл бүхий нутаг дэвсгэрт халдварт өвчин оношлогдсон,

3.1.2. Мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн тээврийн хэрэгсэл, тээвэрлэгч солигдсон,

3.1.3. Мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн малын төрөл, тоо зөрсөн, цахим бүртгэлийн сантай мэдээлэл зөрсөн,

3.1.4. Мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн дамжин өнгөрөх замын маршрут зөрсөн, дамжин өнгөрөх мал эмнэлгийн хяналтын цэгийн бүртгэл, тэмдэглэгээ хийгдээгүй, хяналтанд ороогүй,

3.1.5. Тээврийн хэрэгсэл мал, амьтны халдварт өвчний голомт илэрсэн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрсөн тухай мал эмнэлгийн эрх бүхий байгууллагаас мэдээлэл ирүүлсэн,

3.1.6. Монгол Улсын Засгийн газраас тогтоосон мах бэлтгэл, отор нүүдлийн зорилгоор аймаг дамжин мал туух тууврийн замын чиглэл зөрчигдсөн,

3.2. Мал эмнэлгийн хяналт цэгт болон туувар, тээврийн замд саатуулсан мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7. хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3. Энэхүү журмын 3.2 дах хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлснээс гарах зардлыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8. дахь хэсэгт заасны дагуу мал, амьтныг тээвэрлэж, тууварлаж, унаж, эдэлж байгаа иргэн, хуулийн этгээд хариуцна.

Дөрөв. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

4.1. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийж буй иргэн, хуулийн этгээд нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4. дэх хэсэгт зааснаас гадна дараахь үүрэг хүлээнэ.

4.1.1. Энэхүү журамд заасан эрх бүхий мал эмнэлгийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр аймаг, сумын нутагт отор нүүдэл хийх,

4.1.2. Мал, амьтныг шилжилт хөдөлгөөн хийж туувурлаж, тээвэрлэхэд эрх бүхий байгууллагаас тогтоосон замын маршрутын дагуу явах,

4.1.3. Мал, амьтан тээвэрлэх, тууварлах талаар эрх бүхий мал эмнэлгийн байгууллагаас баталсан заавар, малын эмчийн өгсөн зааврыг мөрдөх,

4.1.4. Отор, нүүдлийн зорилгоор шилжилт хөдөлгөөн хийж өөр аймаг, сумын нутагт тухай шатны Засаг даргаас тогтоож өгсөн нутагт оторлох,

4.1.5. Отор, нүүдэл хийх болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийхэд тухайн сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн шаардсан үзлэг шинжилгээ болон мал эмнэлгийн арга хэмжээнд бүрэн хамруулах,

4.1.6. Төлөвлөгөөт бус мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдахад гарах зардлыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3. дахь хэсэгт заасны дагуу хариуцах,

4.2. Малын шилжилт хөдөлгөөн хийхтэй холбоотойгоор бүх шатны мал эмнэлгийн байгууллагын ажил, үйлчилгээний талаар санал гомдлоо дээд шатны байгууллагад гаргах эрхтэй

Тав. Малын шилжилт хөдөлгөөнд хориглох үйл ажиллагаа

5.1. Мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийхэд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12 дахь хэсэгт зааснаас гадна дараахь үйл ажиллагааг хориглоно.

5.1.1. Эрх бүхий мал эмнэлгийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт отор, нүүдэл хийхийг,

5.1.2. Хот, суурин газар, хүн амын сууршлийн нутаг дэвсгэрт болон тогтоосон цэгээс бусад газарт мал амьтан тээвэрлэсэн тээврийн хэрэгсэл түр саатах, тээвэрлэн яваа мал, амьтныг түр амраах, буулгах, шилжүүлэн тээвэрлэх, тууврийн малыг хоноглуулахыг,

5.1.3. Отор нүүдэл хийж буй болон тээвэрлэж, тууварлаж яваа мал, амьтныг тухай сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн зөвшөөрөлгүйгээр худалдаалах, мал, амьтныг солих, үлдээхийг,

5.1.4. Туувар, тээврийн замд хорогдсон мал амьтны хүүр, сэг зэмийг тухайн сум, дүүргийн мал эмнэлгийн тасгийн зөвшөөрөлгүйгээр усгах, хаяхыг,

5.1.5. Туувар, тээврийн замд мал, амьтанд ямар нэг өвчний сэжиг илэрсэн тухай мэдээллийг туай сум, дүүргийн мал эмнэлгийн тасагт мэдэгдэхгүй нууцлахыг,

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл ногдуулна.